



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 2024 оны
санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/111/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.12.25 № 141
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар багийн нутаг дэвсгэрт аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 01-А/341 дугаар захирамжаар 960 суудалтай сургуульд "Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургууль" гэсэн улсын дугаар олгож, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 12 жилийн хугацаатай олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг нэмэгдүүлэн тодотгол хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 89.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	220,067,514.17
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	184,114,610.17
31210	Төгрөг	0.00	184,114,610.17
31211	Төрийн сангийн харилцах	0.00	184,114,610.17
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	35,952,904.00
35100	Түүхий эд материал	0.00	379,840.00
35130	Эм боох материал	0.00	379,840.00
35400	Хангамжийн материал	0.00	35,573,064.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	1,009,000.00
35420	Аж ахуйн материал	0.00	11,953,500.00
35460	Хүнсний материал	0.00	11,545,364.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	11,065,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	8,688,011.66
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	8,688,011.66
39200	Биет хөрөнгө	0.00	6,588,011.66
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	6,346,345.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(58,333.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	0.00
39300	Биет бус хөрөнгө	0.00	2,100,000.00
39301	Програм хангамж	0.00	2,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	228,455,525.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0.00	0.00
41300	Өглөг	0.00	0.00
41360	Бусад өглөг	0.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
42200	Урт хугацаат зээл	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	228,455,525.83
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	228,455,525.83
51100	Засгийн газрын оруулсан капитал	0.00	0.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	228,455,525.83
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	228,455,525.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	228,455,525.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1,091,794,745.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	22,217,745.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	22,217,745.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	8,666,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	8,366,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	300,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	2,486,345.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	11,065,200.00
121	Хөрөнгийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,069,577,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,024,577,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,024,577,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	45,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	45,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	863,339,219.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	863,339,219.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	855,038,069.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	653,836,365.93
210101	Үндсэн цалин	0.00	445,478,506.76
210102	Нэмэгдэл	0.00	195,304,359.17
210104	Урамшуулал	0.00	13,053,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	78,823,891.61
210201	Тэтгэврийн даатгал	0.00	55,242,282.04
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	6,072,702.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	3,054,469.29
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	2,885,032.08
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	11,569,405.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	31,698,850.61
210301	Гэрэл, цахилгаан	0.00	9,108,972.93
210302	Түлш, халаалт	0.00	11,352,103.40
210303	Цэвэр, бохир ус	0.00	11,237,774.28
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	10,313,520.00
210401	Бичиг хэрэг	0.00	5,657,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	4,656,420.00
2105	Нормативт зардал	0.00	54,474,696.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	318,610.00
210502	Хоол, хүнс	0.00	54,156,086.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	14,759,482.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	8,366,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	6,393,282.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,131,263.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,072,930.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	58,333.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,301,149.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	8,301,149.39

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	8,301,149.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.00	228,455,525.83
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	228,455,525.83
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1,078,543,200.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	8,966,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	8,966,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	8,666,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	8,366,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	300,000.00
120009	Бусад орлого	0.00	300,000.00
121	Хөрөнгийн орлого	0.00	0.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,069,577,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,024,577,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,024,577,000.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	45,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	45,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	888,468,589.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	888,468,589.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	814,465,990.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	653,836,365.93
210101	Үндсэн цалин	0.00	445,478,506.76
210102	Нэмэгдэл	0.00	195,304,359.17
210104	Урамшуулал	0.00	13,053,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	78,823,891.61
210201	Тэтгэврийн даатгал	0.00	55,242,282.04
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	6,072,702.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	3,054,469.29
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	2,885,032.08
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	11,569,405.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	31,698,850.61
210301	Гэрэл, цахилгаан	0.00	9,108,972.93
210302	Түлш, халаалт	0.00	11,352,103.40

210303	Цэвэр, бохир ус	0.00	11,237,774.28
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	5,000,000.00
2108 *	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	20,189,482.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	8,366,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	11,823,282.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	24,917,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	19,827,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	5,089,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	74,002,599.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	65,701,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	65,701,450.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	8,301,149.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	8,301,149.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	184,114,610.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	5,960,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	5,960,000.00
222001	Тонг төхөөрөмж	0.00	3,860,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	2,100,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-5,960,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	184,114,610.17
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	184,114,610.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчилөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн				
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчилөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	228,455,525.83	228,455,525.83
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	228,455,525.83	228,455,525.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00		
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			0.00	0.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,144,599,500.00	885,827,440.44	(258,772,059.56)	77.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,144,599,500.00	885,827,440.44	(258,772,059.56)	77.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,078,202,000.00	820,125,990.44	(258,076,009.56)	76.1
210101	Үндсэн цалин	793,385,600.00	653,836,365.93	(139,549,134.07)	82.4
210102	Нэмэгдэл	519,016,900.00	445,478,506.76	(73,538,393.24)	85.8
210104	Урамшуулал	261,315,100.00	195,304,359.17	(66,010,740.83)	74.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,053,500.00	13,053,500.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	99,173,200.00	78,823,891.61	(20,349,308.39)	79.5
210202	Тэтгэмжийн даатгал	67,437,800.00	55,242,282.04	(12,195,517.96)	81.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,933,900.00	6,072,702.92	(1,861,197.08)	76.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,966,900.00	3,054,469.29	(912,430.71)	77.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,966,900.00	2,885,032.08	(1,081,867.92)	72.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,867,700.00	11,569,405.28	(4,298,294.72)	72.9
210301	Гэрэл, цахилгаан	106,356,300.00	31,698,850.61	(74,657,449.39)	29.8
210302	Түлш, халаалт	20,000,000.00	9,108,972.93	(10,891,027.07)	45.5
210303	Цэвэр, бохир ус	72,052,200.00	11,352,103.40	(60,700,096.60)	15.8
2104	Хангамж, бараа материалын зардал	14,304,100.00	11,237,774.28	(3,066,325.72)	78.6
2105	Нормативт зардал	0.00	0.00	0.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00	0.00	0.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00	0.00	0.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,326,200.00	26,149,482.29	(11,176,717.71)	70.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,366,200.00	8,366,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,960,000.00	17,783,282.29	(11,176,717.71)	61.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,960,800.00	24,617,400.00	(12,343,400.00)	66.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,871,200.00	19,527,800.00	(12,343,400.00)	61.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,089,600.00	5,089,600.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,397,500.00	65,701,450.00	(696,050.00)	99.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,397,500.00	65,701,450.00	(696,050.00)	99.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,144,599,500.00	1,069,942,050.61	(74,657,449.39)	93.5

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,024,577,000.00	1,024,577,000.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,024,577,000.00	1,024,577,000.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	111,356,300.00	36,698,850.61	(74,657,449.39)	33.0
132001	Орон нутгийн төсвөөс	111,356,300.00	36,698,850.61	(74,657,449.39)	33.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,666,200.00	8,666,200.00	0.00	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,366,200.00	8,366,200.00	0.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	300,000.00	0.00	100.0
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		184,114,610.17	184,114,610.17	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	84.00	84.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	59.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	23.00	23.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (РЖИЛИЙН ДУНДЖААР)	960.00	1,089.00	129.00	113.4
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	960.00	1,089.00	129.00	113.4
630002	Хувийн ЕБС	960.00	1,089.00	129.00	113.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургууль нь "Суралцагчдын суралцах чадварыг дээшлүүлж, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн эерэг зөв хандлагатай иргэн болгон төлөвшүүлэх" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэл, зорилтыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хүүхэд бүрийн онцлог ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан хоцрогдлыг нөхөх, арилгах, үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж сурлагын амжилтад ахиц гаргах,
- Хүүхэд хамгаалалын асуудлыг чухалчилан тэдний хүмүүжил төлөвшилд эерэг өөрчлөлт гаргаж, тэднийг зөв иргэн болгон төлөвшүүлэх,
- Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг дэмжин үйл ажиллагааг зохион байгуулж багшийг тасралтгүй хөгжих боломж нөхцөлөөр хангах,
- Сургалтын орчинг орчин үеийн жишигт нийцсэн байдлаар тохижуулж цахим технологиудыг сургалтад нэвтрүүлэн ашиглах,
- Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийттэй хамтран ажиллаж, тэдний оролцоог нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 82 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 2024 оны 12 дугаар сарын 26 өдрийн А/30 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж, өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тухайн бүрт хянан шийдвэрлэж ажиллаж байхаар тусгасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тус сургууль 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 228,455.5 мянган төгрөг болсон нь Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 01-А/341 тоот захирамжаар 2024 оны 7 дугаар сараас эхлэн шинээр ашиглалтанд орж үйл ажиллагаагаа эхлүүсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	184,114.6	184,114.6
Авлага	-	-	-
Бараа материал	-	35,952.9	35,952.9
Үндсэн хөрөнгө	-	8,388.0	8,388.0
Нийт хөрөнгө	-	228,455.5	228,455.5
Богино хугацаат өр төлбөр	-	0.0	0.0
Эздийн өмчийн дүн	-	228,455.5	228,455.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	228,455.5	228,455.5

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 184,114.6 мянган төгрөг болсон нь тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 35,952.9 мянган төгрөг болсон нь төсвийн хөрөнгөөр 96,624.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Боловсролын газраас 11,065.2 мянган төгрөгийн ном сурах бичгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 71,736.8 мянган төгрөгийн бараа материал үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Тус сургууль нь хэвийн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш төсвийн хөрөнгөөр 5,960.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалан авч, Боловсролын яамнаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 2,486.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд орлого авсан байна. Одоогоор ашиглагдаж байгаа барилга байгууламж, сургалтын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бусад хөрөнгүүдийн орлого авах дээд шатны шийдвэр ирээгүй тул 2024 оны санхүүгийн тайланд орлого аваагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 228,455.5 мянган төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургууль нь 2024 оны 9 дүгээр сард үндсэн үйл ажиллагаа эхлүүсэн учир төсвийн төсөл боловсруулаагүй байна.

2024 оны 9 сард зөвхөн тухайн сарын үйл ажиллагааг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 249,626.1 мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Тайлант хугацаанд төсвийн хуваарьт 2 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 1,024,577.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвийг 111,356.3 мянган төгрөг байхаар тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,024,577.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 111,356.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 8,366.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 300.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,144,599.5 мянган төгрөгийн эх үүсвэр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,024,577.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8,366.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 300.0 мянган төгрөг, нийт 1,078,243.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зарлагын гүйцэтгэл 885,827.4 мянган төгрөг буюу 77.4 хувьтай зарцуулж, 8,301.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зарцуулаагүй үлдсэн 184,114.6 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	801 f1	Тогтмол зардал	111,356,300.00	36,698,850.61	(74,657,449.39)	33.0
2	80226	Байр ашиглалт үйлчилгээ	2,573,400.00	2,573,400.00	0.00	100.0
3	80233	Хүүхэд хамгаалал	2,573,200.00	2,573,200.00	0.00	100.0
4	80312	Сургалт семинарын зардал	2,062,300.00	-	(2,062,300.00)	-
5	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	2,500,000.00	-	(2,500,000.00)	-
6	81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	7,595,600.00	2,500,000.00	(5,095,600.00)	32.9
7	81801	Үдийн цай хөтөлбөр	66,397,500.00	66,701,450.00	(696,050.00)	99.0
8	81834	Боловсролын стандарт	918,519,000.00	750,131,057.54	(168,387,942.46)	81.7
9	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	11,970,000.00	11,970,000.00	0.00	100.0
10	84844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	300,000.00	300,000.00	0.00	
11	81875	Сурах бичиг түрээс	8,366,200.00	8,366,200.00	0.00	100.0
12	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	10,386,000.00	5,013,282.29	(5,372,717.71)	48.3
Нийт дүн			1,144,599,500.00	885,827,440.44	(258,772,059.56)	77.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны 9 дүгээр сард үндсэн үйл ажиллагаа эхлүүсэн учир худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй байна. ТБОНӨХБАУХА тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны 11 сарын тодотгол орж батлагдсан төсөв 1,033,000.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 20,660.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад зарлагын 61,530.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ, 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 44,968.4 мянган төгрөгийн 10 шийдвэр тус тус мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Өгсөн зөвлөмж¹:

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд, бүрэн байршуулж ажиллах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны 9 дүгээр сараас үйл ажиллагаа нь эхэлсэн тул санал дүгнэлт байхгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч тухайн сургуулийн барилга байгууламж, сургалтын тоног төхөөрөмж, бусад биет болон биет бус хөрөнгүүдийг санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэж аваагүй байна. Тухайлбал сургуулийн барилга, барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын 2024 оны 05 дугаар сарын 08 өдрийн 11/2024-Д дугаар дүгнэлтээр байнгын ашиглалтанд оруулсан боловч бүртгэлд тусгаагүй нь хөрөнгийн ашиглах жил, тухайн жилийн санхүүгийн үр дүнгийн тайланд ихээхэн нөлөө үзүүлэх тул, хөрөнгийг холбогдох байгууллагуудаар шийдвэр гаргуулан бүртгэлд тусган авах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,374.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,046.3 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 11,327.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитын явцад дараах алдаануудыг залруулсан. Үүнд:

- Төрийн сангийн дансны хуулгаар нэр данс зөрүүтэй буцсан 300.0 мянган төгрөгийн гүйлгээг залруулсан.
- Бараа материалын дансанд хөрөнгийн шинж чанартай агуулсан 4,160.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил орлого авсан.
- Үндсэн хөрөнгийн тайланд, 2,100.0 мянган төгрөгийн санхүүгийн программ орлого аваагүй.
- Боловсролын яамнаас шилжин ирсэн 2,486.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орлого аваагүй байгаа нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", УСНББОУС 12 "Бараа материал", УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 8, 10 дугаар бүлэг "Ангилал", "Толилуулга", батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланг залруулав.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ур чадварын нэмэгдэлийн шалгуур үзүүлэлт, нэмэгдэл олгох журам боловсруулан төсвийн шууд захирагчаар батлуулаагүй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, "Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, нэмэгдэл олгох журам боловсруулан ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

2. Бараа материалын тайлан, орлого зарлагыг түүвэрлэн шалгахад 3,748.5 мянган төгрөгийн бараа материалыг дансны ангилал буруу бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Сангийн

сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10 дугаар хавсралт "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө" заалтуудыг зөрчсөн ба "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Бараа материалыг зөв ангилан бүртгэж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

3. Тайлант оны хүнсний материалын орлого зарлагыг тулган шалгахад 7,579.3 мянган төгрөгийн хүнсний материалын нөөц үүсгэн худалдан авалт хийж бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хүнс, хүнсний бүтээгдэхүүн их хэмжээгээр нөөцлөн хадгалснаар чанар, стандартад сөргөөр нөлөөлөх тул бараа материалын үлдэгдэлийг зөв зохистой тооцоолон, байнгын хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээг залруулсан.	1	300.0	1	300.0			1	300.0				
Санхүүгийн тайланд залруулга хийсэн	1	4,160.0			1	4,160.0	1	4,160.0				
Санхүүгийн тайланд залруулга хийсэн	1	2,100.0	1	2,100.0			1	2,100.0				
Санхүүгийн тайланд залруулга хийсэн	1	2,486.3	1	2,486.3			1	2,486.3				
	4	9,046.3	3	4,886.3	1	4,160.0	4	9,046.3	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчилийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын ангилал буруу хийгдсэн байна.	1	3,748.5					1	3,748.5				
Нэмэгдэл олгох журам боловсруулаагүй	1	0.0					1	0.0				
Хүнсний материалын нөөц их үүссэн.	1	7,579.3					1	7,579.3				
	3	11,327.8					3	11,327.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад зарлагын 7 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 10 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна.	1	106,498.5					1	106,498.5
Дүн	1	106,498.5					1	106,498.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	106,498.5					1	106,498.5